

Дундговь аймгийн ИТХ-ын 2020 оны сонгуульд
бие даан нэр дэвшигч Төгсийн Мөнхбаярын
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Миний бие аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшиж ялалт байгуулвал дараах мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. Иймд Дундговь аймгийн Төрийн аудитын газарт орон нутгийн сонгуулийн хуульд заасан хугацаанд сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрөө хүргүүлж байна. Холбогдох хуулийн дагуу хянаж үзнэ үү.

Мөрийн хөтөлбөрийн уриа: Айраг багаас эхэлье

Зорилго: Орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьдралын чанарыг нь сайжруулах.

Зорилт 1. Иргэдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр:

- 1.1 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр орон нутагт хийгдэх ажлын тендерт Орон нутгийн ажиллах хүчний давуу байдлыг тооцдог болох талаар санал гаргаж ажиллана. Ингэснээр аймгийнхаа ААН-үүдийг тендерт шалгарах боломжийг нэмэгдүүлэн орон нутгийн бизнес эрхлэгчид, компаниуд эдийн засаг, хүний нөөцийн хувьд чадавхижиж, ажилгүйдэл буурч, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.2 Айраг багийн иргэдийг байнгын болон түр ажлын байраар хангах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Зорилт 2. Орон нутгийн хөгжлийн асуудлаар шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр:

- 2.1 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, гүйцэтгэх ажлын саналыг орон нутгийн удирдлагууд өөрсдөө гаргаад иргэдээр дэмжүүлдэг тогтолцоог багийн иргэдээс гарсан саналуудыг орон нутгийн удирдлагууд дэмжиж, хэрэгжүүлж ажилладаг зөв зарчимд нь оруулна. Ингэснээр иргэд орон нутагтаа хийх ажлыг өөрсдийн саналаар шийддэг зарчим тогтооно.
- 2.2 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, шинжилгээ үнэлгээний ажлыг иргэд, орон нутгийн төрийн бус байгууллага хамтран гүйцэтгэдэг механизм бий болгох асуудлыг шийдвэрлүүлнэ. Үүний үр дүнд зээл, хөнгөлөлттэй зээлийн ашиглалт, үр дүн сайжирч орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулна.
- 2.3 Иргэний нээлттэй танхимаар дамжуулан бүх төрлийн мэдээ мэдээллийг нийт иргэдэд хүргэх, түгээх, олон нийтийн оролцооны нээлттэй хэлэлцүүлэг хийдэг үйл ажиллагааг хэвшүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хамтран ажиллах, хянах, хариуцлага тооцох бололцоог бүрдүүлнэ.
- 2.4 Айраг багийн оюутан, сурагчдаас сурч хөгжих хүсэлтэй, оюуны чадамжтай зорилтот бүлгийн хүүхдүүдийг дэмжиж ажиллана.
- 2.5 Айраг багийн хүүхдүүдийг сургууль, цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3. Иргэдийн амьдрах орчин, амьдралын чанарыг сайжруулах чиглэлээр:



- 3.1 Аймгийн төвийн ундны усны хатуулгийг бууруулах, цэнгэгшүүлэх төхөөрөмж суурилуулах асуудлыг санаачилж, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар иргэдийг хангахад анхаарч ажиллана.
- 3.2 Хог хаягдлын менежментийг сайжруулах, хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэрлэл эрхлэх иргэд, ААН-д орон нутгаас бодлогын дэмжлэг үзүүлэх талаар санаачилга гаргаж ажиллана.
- 3.3 Айраг багт амьдардаг Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.4 "Архигүй айраг баг" арга хэмжээг жил бүр зохион байгуулж амьдрах ухааны чиглэлээр сургалт, явуулна.
- 3.5 Айраг багт хүүхдийн тоглоомын талбай байгуулж, орчны стандартыг мөрдүүлж хүүхдийн аюулгүй орчинд тоглох нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.6 Айраг багийн гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.
- 3.7 Айраг хорооллын инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлж цэвэр, бохирын төв шугаманд холбогдох айл, өрхийн тоог нэмэгдүүлнэ.
- 3.8 Айраг хорооллын өрхүүдийг дулааны шугамд холбох нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.9 Айраг хорооллын газрыг дахин зохион байгуулж "Жишиг шинэ гудамж" төслийг хэрэгжүүлнэ.
- 3.10 "Орлогд нийцсэн орон байр" буюу хашаандаа тав, тухтай сайхан амьдрах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.11 Аюулгүй тайван амьдрах орчинг бүрдүүлж бүх гудамжийг хяналтын камертай болгож гэмт хэрэг, зөрчилгүй "Цахим баг" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.12 Айраг багийн өрхийн эмнэлгийн барилгыг засварлах буюу өргөтгөлийг орон нутгийн болон улсын төсвийн санхүүжилтээр хийж гүйцэтгүүлнэ.
- 3.13 Өрхийн эрүүл мэндийн төвд авто машин, тоног төхөөрөмжийн хангалтыг стандарт түвшинд хүргэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 3.14 Соёл амралтын хүрээлэнг бүрэн засварлаж гэр бүл, хүүхэд, оюутан залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх түүх, соёлын цогцолбор байгуулна.
- 3.15 Айраг багт ахмад настны мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлсэн "Ахмадын хөгжлийн төв"-г барьж үйл ажиллагааг нь тогтмол явуулна.

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ



Т.МӨНХБАЯР

Хаяг: Дундговь аймаг Сайнцагаан сум 8-р баг Айраг 8-4 тоот

Регистрийн дугаар: ЗЮ86013118

Утас: 8811-7895

